

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж: Нэгдүгээр хэсэг нь 56 сонгох даалгавартай нийт 80 оноотой. Даалгавар тус бүр 5 сонгох хариулттай. Тэдгээрийн зөвхөн нэг хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.** Амжилт хүсье.

- Цэгийн оронд тохирох хариултыг сонгоно уу. /1 оноо/
Нийгэмшилтийн явцад хувь хүн өөрийгөө нийгмийн тодорхой бүлэг, нийтлэг нийгэмд харьяалуулан, тэдгээрийг илэрхийлэгч онцлог шинжийг тээгч нь болдог. Үүнийггэдэг.
A. Нийгэмшилт B. Дахин нийгэмшилт C. Адилсал
D. Нийгэмшилтийн агент E. Нийгмийн гажуудал
- Бүтэц чиг үүргийн онолын гол төлөөлөгч Р.Мертон нийгмийн институтийн чиг үүргийн хэлбэрүүдийг тодорхойлсон байдаг. Далд чиг үүрэгт хамаарах өгөгдөл аль нь вэ? /1 оноо/
A. Тухайн байр суурь бүхий хүн юуг хийх нь зөвшөөрөгдөж байгаа үйлдэл
B. Тухайн үйлдлийг гүйцэтгэгчээс мэдэж тооцоолсон үр дагавар
C. Үйлдэл нь зорьсныхоо эсрэг үр дагаварт хүргэх
D. Тухайн үйлдэгч урьдчилан тооцоолоогүйгээр бий болсон үр дагавар
E. Тухайн байр сууриас үүдэн бий болж, заавал биелүүлэх ёстой үйлдэл

- Дараах хүснэгтээс нийгмийн гажуудлын харьцангуй мөн чанар болон түүнд тохирох жишээг олно уу. /2 оноо/

Хүснэгт-а		Хүснэгт-б	
1	Нийгмийн хэм хэмжээ, хүлээлтэд нийцэх төлөв	1	Бүхий л нийгэмд хулгай хийх, эд мөнгөнд хохирол учруулах, архинд донтох, хар тамхи хэрэглэх үйлдэл байсаар байна.
2	Нийгэм болон нийгмийн бүлгийн олонх гишүүдийн хүлээн зөвшөөрсөн хүлээлтэд үл нийцэх төлөв	2	Эрэгтэйчүүд гэртээ суугаад нүүрээ будаж эмэгтэйчүүдэд тоогдохыг хичээх үйлдэл нь улс орнуудын үнэлэмж, ёс заншлаас хамаарч өөр өөрөөр үнэлэгддэг.
3	Гажуудал нь нийгмээсээ хамаараад харьцангуй мөн чанартай	3	Орчин үеийн нийгэмд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн үнэлэмжид тэгш хандах хандлага илүү их болсон.

- A. a-2, b-3 B. a-3, b-2 C. a-3, b-1 D. a-1, b-1 E. a-2, b-2

- Социологич Д.Датон ядуу хүмүүс бодит хэрэгцээнээсээ бага эрүүл мэндийн үйлчилгээ авч байгааг хэд хэдэн хүчин зүйлээс хамаарч байна гэж үзсэн. Хүснэгт дэх өгөгдлийг ажиглаад орхигдсон хүчин зүйлийг гүйцээгээрэй. /1 оноо/

Д.Датон	
	Ядуусын соёл
	Нийгмийн институтын саад бэрхшээл

- A. Ур чадвараар бага, даржин амьдрал B. Эдийн засгийн хувьд амжилттай байдал
C. Хувийн хичээл зүтгэл D. Хувийн хүчин зүйл
E. Санхүүгийн боломж

- Нийгмийн тэгш бус байдал, давхраажилт оршин байгаагийн учир шалтгааныг тайлбарласан “социологийн орчин үе”-ийн төлөөлөгчдийг сонгоно уу. /1 оноо/
A. О.Райт, Л.Уорнер B. К.Маркс, О.Райт C. М.Вебер, К.Маркс
D. М.Вебер, О.Райт E. К.Маркс, Л.Уорнер
- Судлаач О.Мөнхбатын “дунд” ангийн талаарх дүгнэлтэд үл хамаарах өгөгдлийг олно уу. /1 оноо/
A. Төр засгийн дунд албан тушаалтан, хэрэгжүүлэгч агентлагийн удирдлагууд багтдаг.
B. Нийгмийн бүх бүлгээс төлөөлөлтэй, дийлэнх хувьд нь ажил олгогчид биш, ажилтнууд багтдаг.
C. Жижиг дунд аж ахуйн нэгжийн захирал, дунд гарын бизнесменүүд, чинээлэг малчид багтдаг.
D. Банк санхүү, томоохон аж ахуйн нэгжийн захирал, соёл, спортын элит бүлэг багтдаг.
E. Эмч, их дээд сургуулийн багш, төр засгийн доод албан тушаалтан багтдаг.



7. Байр суурийн шилжих хөдөлгөөний хэлбэрүүдийг өгөгдөлтэй нь зөв харгалзуулна уу. /2 оноо/

а. Хэвтээ чиглэлийн шилжих хөдөлгөөн b. Үе хоорондын шилжих хөдөлгөөн с. Хувийн шилжих хөдөлгөөн	1	Эцэг эх, гэр бүлийн төрөлхийн байр суурьтай нь харьцуулалгүйгээр хувь хүний байр суурь өөрчлөгдсөн бол
	2	Нийгмийн бүтцийн өөрчлөлттэй холбогдон нийгмийн тодорхой бүлгийн гишүүдийн байр сууринд өөрчлөлт гарсан бол
	3	Хувь хүний нийгэм эдийн засгийн байр сууринд өөрчлөлт гараагүй бол
	4	Тодорхой хувь хүнээс хамааран, түүний хичээл зүтгэл, авьяас чадвар, хөдөлмөрийн үр дүнд байр сууринд өөрчлөлт гарах
	5	Ч нь 1999 онд Архангай аймгийн Ихтамир суманд малчин М-ийн гэр бүлд төрсөн. Тэрээр 2021 онд их сургууль төгссөн. 2021 оноос захирлын албыг хашиж байна.

- A. a3, b1, c5 B. a1, b2, c3 C. a2, b5, c4 D. a3, b5, c4 E. a2, b3, c1

8. Дараах тоон мэдээллийг ашиглан эрэгтэйчүүдийн үйлдсэн гэмт хэргийн хувийн жинг тооцно уу. /2 оноо/

Нийгмийн байдлаар	Тоо	Нийгмийн байдлаар	Тоо
1. Ажилгүй	12532	2. Сурагч	644
3. Хувиараа хөдөлмөр эрхлэгч	4501	4. ТББ-ын ажилтан	465
5. Хувийн хэвшилд ажиллагч	2212	6. Тэнэмэл	190
7. Малчин	2144	8. Хоригдол	45
9. Төрийн албан хаагч	1018	10. Сургууль завсардсан	38
11. Оюутан	1053	12. Хугацаат цэргийн албан хаагч	15
Нийт			24857
Эрэгтэй	21075	Эмэгтэй	3782

- A. 847,8 B. 84,7 C. 3782 D. 0,847 E. 21075

9. Доорх өгөгдлүүдийн “үнэн”, “худал”-ыг тогтооно уу. /2 оноо/

№	Өгөгдөл	Үнэн	Худал
1	Т.Парсонс нийгмийн хувьсал бол нийгмийн институтүүдийн ялгарлын өсөн нэмэгдэлт гэж үзсэн.		
2	Бүтэц чиг үүргийн онолчид нийгэмд гарах гэнэтийн өөрчлөлтийг хүсмээр зүйл биш хэмээн үздэг.		
3	К.Маркс нь М.Веберийг шүүмжлэхэд гол анхаарлаа хандуулсан. Тэрээр хувьслын онолыг бас шүүмжилсэн.		
4	К.Марксийн хувьд хүрээлэн буй орчинд дасан зохицох бус, харин түүнийг өөрчилдөг гэдэгт анхаарлаа хандуулдаг.		

- A. 1 худал, 2 үнэн, 3 үнэн, 4 худал B. 1 үнэн, 2 худал, 3 үнэн, 4 худал
C. 1 үнэн, 2 үнэн, 3 худал, 4 үнэн D. 1 үнэн, 2 үнэн, 3 үнэн, 4 худал
E. 1 худал, 2 худал, 3 үнэн, 4 худал

10. Шинжлэх ухааны доктор, профессор С.Дуламын үзэл санаанд хамаарах ойлголтыг сонгоно уу. /1 оноо/

- A. Соёл бол янз бүрийн бэлгэ тэмдгүүдийн нэгдэл мөн.
B. Овог аймгуудын хэл, домог, шашин, урлаг зэрэг соёлын үзэгдлийг судалсан.
C. Хүн бол бэлгэдэл бүтээгч амьтан бөгөөд бэлгэдлийн ертөнцөд амьдардаг.
D. Домог, хэл, урлаг, шашин, түүх, шинжлэх ухааны ертөнц юм.
E. Хүн гэдэг амьтны адгууснаас ялгарч байгаа нэг гол шинж нь бэлгэдэл мөн.



11. Соёлыг бүрдүүлэгч элементүүдийг тохирох жишээтэй нь зөв тохируулна уу. /1 оноо/

а. Үнэлэмж б. Мэдлэг с. Бэлгэ тэмдэг	1	Малчид болжмор бөөгнөрөхөд цас ордог, галуу дуугарахад бороошдог хэмээн хэлэлцдэг.
	2	Монгол улсын ерөнхийлөгч нь ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.
	3	Хөлөө хавчин суух нь сэтгэл санаа зовнисны шинж гэдэг.
	4	Өмнөх үеийн бүтээсэн нийгэм соёлын уламжлалыг өвлүүлэх нь нийгмийн оршихуйн үндэс юм.
	5	Сайн үйл, шударга ёс, эрх чөлөөг аль ч ард түмэн эрхэмлэдэг.

A. a4, b1, c3 B. a5, b1, c2 C. a2, b4, c3 D. a5, b1, c4 E. a2, b4, c5

12. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/

..... нь зонхилогч соёлоос бага зэргийн ялгаатай боловч түүнтэй нийцэж байдаг соёл юм.

A. Олон улсын соёл B. Зонхилогч соёл C. Сөрөг соёл
D. Дэд соёл E. Улс үндэсний соёл

13. Хүснэгтийн хоосон зайд тохирох өгөгдлийг зөв тохируулна уу. /1 оноо/

Өгөгдөл: (1-Улс төр, 2-Газар нутаг, 3-Ястан)

а	б	с
Угсаатны нийтлэгийн хоёр дахь нь юм.	Үндэс угсаа, хэл, соёл, түүх, зан заншил,, шашин зэргээр нийтлэг нийгмийн бүлэг бол угсаатан юм.	Үндэс угсаа, хэл, аж ахуй,-ийн хувьд ижил байхыг илэрхийлдэг ойлголт бол үндэстэн юм.

A. a-3, b-1, c-2 B. a-3, b-2, c-1 C. a-1, b-2, c-3 D. a-2, b-1, c-3 E. a-2, b-3, c-1

14. Харь соёлд дасан зохицох 7 үе шат байдаг. Дараах үе шатуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /2 оноо/

а. С шат б. Е шат с. G шат	1	Харь хэл, орчин, хоол хүнс зэрэг шинэ зүйлсийг хүлээн авч чадахгүйгээс бухимдал үүснэ.
	2	Эргэн тойрныхоо хүмүүсийг ойлгож эхэлж, хүмүүстэй харилцаа тогтоож, аливаад уян хатан хандана.
	3	Бага багаар орчиндоо дасаж, шинэ зүйлийг хүлээн авч чаддаг болно.
	4	Шинэ соёлд дассан боловч, эргэн тойрныхоо хүмүүстэй харилцаа тогтоож чадахгүй.

A. a3, b4, c2 B. a3, b1, c2 C. a4, b1, c3 D. a2, b1, c3 E. a2, b3, c4

15. Доорх өгөгдлүүдийг соёлын түүхэн хэв маяг болон аж ахуй эрхлэлтийн шалгуурт нийцүүлэн ангилна уу. /2 оноо/

1. Хүй нэгдлийн соёл	2. Ан агнуурын соёл	3. Өрнийн соёл
4. Түүвэрлэгчдийн соёл	5. Дорнын соёл	6. Дундад зууны соёл

а. Түүхэн хэв маяг	б. Аж ахуй эрхлэлт

A. a-1, 2 b-4, 6; B. a-2, 4 b-1, 6; C. a-3, 5 b-2, 4;
D. a-2, 4 b-3, 5; E. a-1, 6 b-2, 4;

16. “Хэнд ч байгалиас заяасан засаглах эрх, өөрөөр хэлбэл, хэнд ч бусдыгаа захирах төрөлх эрх гэж байхгүй” гэдэг нь хэний үзэл баримтлал вэ? /1 оноо/

A. Дж.Кэмпбелл B. Ж.Локк C. Э.Фромм D. К.Оберг E. Э.Тайлор



17. Судалж буй юмс, үзэгдлийнхээ гол шинж тэмдэгт тулгуурлан тэдгээрийг тодорхой бүлэгт нэгтгэх аргыг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
 А. Ерөнхийлөл В. Синтез С. Харьцуулалт D. Хийсвэрлэл Е. Ойлголт

18. Юмс ба тэдгээрийн шинж тэмдгийн хоорондын харилцааг батлах, эсвэл үгүйсгэх байдлаар илэрхийлсэн бодомжийг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
 А. Үнэн бодомж В. Харилцаат бодомж С. Худал бодомж
 D. Шинж тэмдгийн бодомж Е. Байхуйн бодомж

19. Дараах ойлголтуудаас хоосон ойлголтыг сонгоно уу. /1 оноо/

1. Чөтгөр	2. Ширээ	3. Бодол
4. Санта Клаус	5. Авьяас	6. Ном

- А. 4, 6 В. 1, 4 С. 3, 5 D. 2, 6 Е. 1, 5

20. Хүснэгтэд буй өгүүлбэрүүдээс бодомж болж чадах өгөгдлийг сонгоно уу. /1 оноо/

1. Э.Кассирер сонгодог эдийн засгийн онолыг боловсруулсан.
2. Чи аль давхраанд хамаарах вэ?
3. Э.Кассирер бэлгэдлийн онолыг боловсруулсан.
4. Нэр хүндэд хүрэх сэн.

- А. 1, 3 В. 2, 3 С. 1, 4 D. 2, 4 Е. 1, 2

21. “Зах зээлийн эдийн засгийн тогтолцоо”-ны үндсэн асуудал аль нь вэ? /1 оноо/

- А. Яаж-Юуг-Хэнд В. Яаж-Хэнд-Юуг С. Хэнд-Юуг-Яаж
 D. Юуг-Хэнд-Яаж Е. Юуг-Яаж-Хэнд

22. Зах зээл дээр барааны үнэ өсөхөд илрэх үзэгдэл аль нь вэ? /2 оноо/

- А. Зах зээлд эрэлтийн тоо хэмжээ өснө, нийлүүлэлтийн тоо хэмжээ өснө, хомсдол үүснэ.
 В. Зах зээлд эрэлтийн тоо хэмжээ буурна, нийлүүлэлтийн тоо хэмжээ буурна, хомсдол үүснэ.
 С. Зах зээлд эрэлтийн тоо хэмжээ буурна, нийлүүлэлтийн тоо хэмжээ өснө, илүүдэл үүснэ.
 D. Зах зээлд эрэлтийн тоо хэмжээ өснө, нийлүүлэлтийн тоо хэмжээ буурна, илүүдэл үүснэ.
 Е. Зах зээлийн тэнцвэр бий болж тэнцвэрт үнэ тогтоно.

23. Дараах тоон мэдээлэл болон томьёог ашиглан МУ-ын 2023 оны эдийн засгийн өсөлтийг тооцно уу. /2 оноо/

№	Он	ДНБ (тэрбум)
1	2022	25
2	2023	30
3	2024	35
4	2025	40

Томьёо:

$$\text{ЭЗӨ} = \frac{\text{ДНБ тайлан} - \text{ДНБ суурь}}{\text{ДНБ суурь}} \times 100\%$$

- А. -20% В. 20% С. -5% D. 5% Е. 0.2%

24. Эдийн засгийн онолын Меркантилизмын үзэл баримтлал аль нь вэ? /1 оноо/

- А. Улс орны баялаг гүйлгээний хүрээнд бий болдог.
 В. Улс орны баялаг зөвхөн хөдөө аж ахуй, газар тариаланд л бүтээгддэг.
 С. Ажилчны бүтээсэн хөлсний хөдөлмөрийг капиталист мөлжих замаар ашгийг бүтээдэг.
 D. Цэвэр буюу төгс өрсөлдөөн нь тогтвортой байдлын өндөр зэргийг хангана.
 Е. Хүн болгоны ашиг хонжоо хайсан үйл ажиллагаа нь нийгмийн баялгийг бүтээдэг.



25. Үнэт цаас худалдан авагчдыг ердийн хүмүүс, өрсөлдөгчид, наймаачид гэсэн 3 хүрээнд хуваадаг. Наймаачид хувьцааг ямар зорилгоор худалдан авдаг вэ? /1 оноо/
- Бүх төрлийн хувьцаа болон бонд, түүнийг худалдах, худалдан авах
 - Өөрсдийн хуримтлалыг ногдол ашгаар арвижуулах
 - Тухайн компанийг өөрийн эрхшээлдээ оруулах
 - Ямар нэгэн компанийн хувьцааг худалдан авах
 - Хувьцааг худалдах худалдан замаар ашиг олох


26. Гүйлгээнд байгаа мөнгөний тоо хэмжээ нэмэгдэж, эдийн засагт инфляци бий болоход Засгийн газраас ямар бодлого баримталбал зохистой вэ? /1оноо/
- Засгийн газраас бонд гаргаж худалдах.
 - Засгийн газраас бондыг эргүүлэн татах.
 - Засгийн газраас хүүгийн бодлогод нөлөөлөх.
 - Засгийн газраас мөнгөний хатуу бодлого баримтлах.
 - Засгийн газраас мөнгөний бодлогод нөлөөлөх.

27. Эдийн засгийн дараах ойлголтуудыг агуулгатай нь зөв тохируулна уу. /2 оноо/

a. Валютын ханш	1	Валютын ханш нь чөлөөтэй өсөж, буурах үзэгдэл
b. Валютын девальваци	2	Төв банкнаас валютын арилжааны ханшийг өсгөх
c. Валютын хөвөгч ханш	3	Валютын тогтсон өртгийг төрөөс бууруулах
	4	Гадаадын нэгж валютыг өөрийн валютаар худалдан авах үнэ.

- A. a4, b2, c1 B. a4, b3, c1 C. a1, b2, c3 D. a2, b3, c4 E. a2, b3, c1

28. График дахь мэдээллийг ашиглан өгөгдөлд тохирох зөв дүгнэлтийг сонгоно уу. /2 оноо/



- 2020 онд мөлхөө, 2023 онд гипер, 2026 онд цогио инфляци, 2020-2026 онд инфляци өссөн.
- 2020 онд мөлхөө, 2023 онд цогио, 2026 онд гипер инфляци, 2020-2026 онд инфляци өссөн.
- 2020 онд цогио, 2023 онд мөлхөө, 2026 онд гипер инфляци, 2020-2026 онд инфляци буурсан.
- 2020 онд гипер, 2023 онд цогио, 2026 онд мөлхөө инфляци, 2020-2026 онд инфляци өссөн.
- 2020 онд гипер, 2023 онд мөлхөө, 2026 онд цогио инфляци, 2020-2026 онд инфляци буурсан.

29. Эрэлт гэж юу вэ? Зөв хариултыг сонгоно уу. /1 оноо/

- Барааны үнэ болон тоо хэмжээний хоорондын хамаарлыг хэлнэ.
- Тухайн зах зээлд нийлүүлэх хүсэл эрмэлзэлтэй бөгөөд үйлдвэрлэх боломжтой бараа үйлчилгээний тоо хэмжээг хэлнэ.
- Иргэдээс бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахдаа төлж буй мөнгөн дүнг хэлнэ.
- Худалдан авагчийн хүсэл сонирхлын үндсэн дээр тодорхой үнээр худалдан авах боломжтой бараа үйлчилгээний тоо хэмжээг хэлнэ.
- Эдийн засагт бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ ерөнхийдөө өсөж буй байдлыг хэлнэ.



30. 1989 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Монголын Ардчилсан холбооны анхны цуглаанд оролцогчдын дэвшүүлсэн уриа, лоозонд аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/
 A. Тусгай хангамж бол хахууль B. We support Perestroika and Glasnost
 C. Эрх зүйт төрийн төлөө D. Хүний эрхийг дээдэлбье E. Нэг намын тогтолцоо

31. Ардчиллын үнэт зүйлсийн тухай хүснэгтийг ажиглаад дутууг дараах хариултаас сонгоорой. /1 оноо/

Ардчиллын үнэт зүйл	Ардчилсан нийгэмд хаан, ерөнхийлөгч, сайд хэн нь ч хуулиас дээгүүр эрх эдлэхгүй.
	Хүн бүр эрх тэгш, чөлөөтэй байх эрхтэй, эрхэм зэрэгтэй төрсөн.
	

- A. Ардчилсан нийгэмд бүх хүн тэгш эрхтэй байх зарчим үйлчилнэ.
 B. Ардчилсан нийгэмд хэн нэгнийг илүү харж, эрх дарх олгохгүй.
 C. Ардчилсан нийгэмд төрийн албан хаагчдад хяналт тавьдаг.
 D. Ардчилсан нийгэмд төрийн гаргасан шийдвэр иргэдийн эрх ашигт нийцдэг.
 E. Олонх нь удирдан захирч, цөөнхийн эрхийг хуулиар дамжуулан хамгаалдаг.

32. “Олон ургалч ардчиллын онол”-ын аль хэсгийн ямар дараалалд алдаа байгааг олоорой. /2 оноо/

Хэсэг	А	Б	В
1-р хэсэг	Нийгмийн доторх бүлэг хэсгүүд өөр хоорондоо өрсөлдөн төрийн эрхийг ээлжлэн барьдаг.	Улс төрийн нам, бүлгүүдийн үүргийг чухалчилдаг.	Төрийн засаглалыг хэрэгжүүлэхэд ард түмэн нийтээрээ оролцох эрхтэй байх.
2-р хэсэг	Төрийн бодлогыг удирдагч цөөнх тодорхойлдог.	Төр засаг нь нам бүлэглэлийн өмнө хариуцлага хүлээдэг.	Бүх хүнийг оролцуулах боломжгүй ч ардчиллын зарчмыг бодитойгоор хэрэгжүүлэх бололцоотой.

- A. 1-р хэсгийн А; 2-р хэсгийн Б B. 1-р хэсгийн В; 2-р хэсгийн А
 C. 1-р хэсгийн Б; 2-р хэсгийн А D. 1-р хэсгийн В; 2-р хэсгийн В
 E. 1-р хэсгийн Б; 2-р хэсгийн В

33. 2024 оны УИХ-ын сонгуулиар 126 гишүүнтэй парламент бүрдүүлэхээр болжээ. Уг сонгуулиар парламентын 78 суудлыг мандатаар, 48 суудлыг намын жагсаалтаар бүрдүүлсэн бол сонгууль ямар тогтолцоогоор явагдсан бэ? /2 оноо/

- A. Мажоритар тогтолцоо, 78 нь холимог тогтолцоо, 48 нь пропорциональ тогтолцоо
 B. Холимог тогтолцоо, 48 нь мажоритар тогтолцоо, 78 нь пропорциональ тогтолцоо
 C. Холимог тогтолцоо, 78 нь мажоритар тогтолцоо, 48 нь пропорциональ тогтолцоо
 D. Мажоритар тогтолцоо, 48 нь холимог тогтолцоо, 78 нь мажоритар тогтолцоо
 E. Мажоритар тогтолцоо, 78 нь мажоритар тогтолцоо, 48 нь пропорциональ тогтолцоо

34. Алмонд, Верба нар өөрсдийн судалгаанд тулгуурлаж улс төрийн соёлын хэв маягуудыг боловсруулжээ. “Овгийнхон” (Parochais) гэсэн хэв маягт хамаарах ухагдахууныг сонгоно уу.

/2 оноо/

- A. Төрийн түшмэд, хуульд идэвхгүй захирагдах боловч саналаа өгдөггүй, улс төрийн амьдралд идэвхтэй татагдан ордоггүй хүмүүс багтана.
 B. Улс төр, төр засгийн талаар тун бүрхэг төсөөлөлтэй, голдуу бичиг үсэг мэдэхгүй, эсвэл улс төрийг огт тоож үздэггүй хүмүүс багтана.
 C. Улс төрийн үйл явцад бодитой оролцож байгаа эсвэл оролцоход бэлэн хүмүүс багтана.
 D. Улс төрийн амьдралын талаар мэдээлэлтэй байж, улс төрийн системд шаардлага тавьж түүнийхээ биелэлтээс хамааран эрх баригчдад дэмжлэг үзүүлэх эсэхээ шийдэж байдаг.
 E. Сонгуульд санал өгөх, нийгэм, улс төрийн амьдралд оролцох, албан тушаалтантай харилцана.



35. Нийгмийн гишүүд үг хэлэх, хэвлэн нийтлэх, аливаа нэг улс төрийн байгууллагаас оюун санааны хувьд бие даасан байдалтай байх нь иргэний нийгмийг төлөвшүүлэх төрийн бодлогын аль хүрээнд хамаарах вэ? /1 оноо/

- A. Оюун санааны хүрээ B. Эдийн засгийн хүрээ C. Нийгмийн хүрээ
D. Улс төрийн хүрээ E. Эрх зүйн хүрээ

36. Улс төрийн засаглалын хүн амын нөөцөд хамаарах өгөгдлийг сонгоно уу. /2 оноо/

- A. Улс төрийн бодлого хэрэгжүүлэх явцад засаглагч өөрийг нь дэмжинэ хэмээн тооцож найдаж байдаг нийгмийн бүлэг, давхраа юм.
B. Үйлдвэрлэл, хэрэглээнд шаардлагатай материаллаг үнэт зүйл, мөнгө санхүү, техник технологи, газар нутаг, ашигт малтмал зэрэг нөөц орно.
C. Арми, цагдаа, аюулгүйн алба, шүүх, прокурор зэрэг нь хүчний байгууллагын үндсэн цөм болно.
D. Хүн бол засаглалын нөөц төдийгүй бас засаглалын субъект, объект мөн.
E. Засаглалд ач холбогдол бүхий мэдлэг мэдээлэл, тэдгээрийг олж авах, түгээх арга хэрэгслүүдийн нийлбэр цогц юм.

37. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоно уу. /1 оноо/

..... нь бүлгийн гишүүдийн сонирхлыг нэг үзүүрт чиглүүлэх буюу нэгтгэдэг. Мөн улс төрийн шийдвэрт тусгуулж чаддаг.

- A. Агрегаци B. Интеграци C. Артикуляци D. Сонирхлын бүлэг E. Эвсэл холбоо

38. Дараах улс орнуудын сонирхлын бүлэг, парламент хоорондын харилцааг зөв харгалзуулна уу. /2 оноо/

a. Их Британи	1	Сонирхлын бүлэг нь ихэвчлэн бизнесийн сонирхол дээр түшиглэдэг.
	2	Сонирхлын бүлгүүд нь гүйцэтгэх засаглалтай холбогддогийнхоо хувьд яамдын сайдууд болон иргэний төлөөлөгч нартай харилцдаг.
b. АНУ	3	Сонирхлын бүлгээс мэргэжлийн хувьд заавар зөвлөгөө авч болохыг зөвшөөрдөг.
	4	Сонирхлын бүлгүүд нь мужийн засаг захиргаатай зөвшилцөлд хүрч чадахгүй байгаа нөхцөлд уг асуудлаа улсын хэмжээнд тавьж хуулиар шийдвэрлүүлдэг.

- A. a1, b2 B. a1, b3 C. a2, b4 D. a3, b4 E. a2, b3

39. Хүний эрхэм чанарын үндсэн шинжид үл хамаарахыг сонгоно уу. /1 оноо/

- A. Хүний эрхэм чанар нь үл хэмжигдэх үнэт зүйл.
B. Хүний эрхэм чанарыг хүнээс салгаж үл болно.
C. Хүний эрхэм чанарт халдаж үл болно.
D. Хүний эрхэм чанар хүн бүрд адил байна.
E. Хүний эрхэм чанар нь хязгааргүй үнэт зүйл.

40. Өгөгдлийг зөв харгалзуулна уу. /2 оноо/

a. Дүүргийн шүүх	1	Хяналтын шатны шүүх
b. Аймгийн шүүх	2	Захиргааны хэргийн шүүх
c. Улсын дээд шүүх	3	Давж заалдах шатны шүүх
	4	Анхан шатны шүүх

- A. a4b3c1 B. a3b1c2 C. a4b1c3 D. a2b1c4 E. a3b2c1

41. Иргэн Д нь боловсролын салбарт олон жил ажилласан, туршлагатай сайн ажилтан. Түүнийг байгууллагын ерөнхий төсөв захиран зарцуулагч нь тодорхойгүй шалтгаанаар ажлаас халах тушаал гаргасан тул дээд шатны байгууллагад хандсан. Иргэн Д захиргааны байгууллагатай ямар хэлбэрээр харилцах вэ? /1 оноо/

- A. Нэхэмжлэл гаргана B. Өргөдөл гаргана C. Хүсэлт гаргана
D. Гомдол гаргана E. Шүүхэд хандана



42. Газрын тухай асуудлаар иргэд захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд ханджээ. Давж заалдах шатны шүүх хэргийг хэд хоногийн дотор хэрхэн хянах вэ? /2 оноо/
 А. Давж заалдах шатны шүүх гомдлыг 14 хоногийн дотор хянаж шийдвэр гаргана.
 В. Давж заалдах шатны шүүх нь хэргийг 30 хоногийн дотор хянаж магадлал гаргана.
 С. Давж заалдах шатны шүүх хэргийг бүхэлд нь хянаж 30 хоногийн дотор тогтоол гаргана.
 D. 30 хоногийн дотор дээд шатны захиргааны байгууллагаар дамжуулан нэхэмжлэл гаргана.
 E. 14 хоногийн дотор дээд шатны захиргааны байгууллагаар дамжуулан гомдол гаргана.
43. А нь найз Б-ээс “Чи надад унадаг дугуйгаа 1 сарын хугацаатай хэрэглүүлээч, би хөлсөнд нь 50000 төгрөг өгье” гэж асуухад Б зөвшөөрчээ. Энэ тохиолдол дахь иргэний эрх зүйн харилцааны агуулгад ул хамаарах өгөгдлийг сонгоно уу. /2 оноо/
 А. Б нь дугуйгаа А-ийн ашиглалтад шилжүүлэх
 В. Б нь мөнгийг А-аас шаардах
 С. Дугуйгаа өмчлөх гэрээнд гарын үсэг зурах
 D. А нь дугуйгаа шилжүүлж өгөхийг шаардах
 E. А нь хөлс болох 50000 төгрөг төлөх
44. Мөнгөөр нөхөн төлөхийг шаардах эрх нь гэм хорыг арилгах аль арга замд хамаарах вэ? /1 оноо/
 А. Сэтгэл санаанд В. Эд хөрөнгөд С. Эрүүл мэндэд D. Амь насанд E. Хор уршигт
45. Иргэд 16 наснаас хөдөлмөрийн гэрээний нэг талаар оролцдог. Тэгвэл хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгөөр хөдөлмөрийн гэрээ байгуулах нас хэд вэ? /1 оноо/
 А. 13 нас В. 15 нас С. 12 нас D. 18 нас E. 14 нас
46. Даатгуулагч Б нь 55 настай, тэрээр тэтгэврийн нэмэгдэл олгох үндэслэлээр 15%-ийн нэмэгдэл авахаар болжээ. Б нь нийт хэдэн жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бэ? /1 оноо/
 А. 20 В. 10 С. 30 D. 15 E. 25
47. Ажилгүйдлийн тэтгэмжийг ямар нөхцөлд олгох вэ? /2 оноо/
 А. Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг 3 болон түүнээс дээш сарын хугацаагаар төлсөн нөхцөлд олгоно.
 В. Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг 24 сараас доошгүй хугацаанд, сүүлийн 9 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд олгоно.
 С. Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг 36 сараас доошгүй хугацаагаар төлсөн нөхцөлд олгоно.
 D. Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг 12 сар, түүний сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд олгоно.
 E. Засгийн газрын тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй нөхцөлд олгоно.
48. “Бага улс” хэмээх ойлголтод ул хамаарах өгөгдлийг олоорой. /2 оноо/

Хэсэг	А	Б	В
1-р хэсэг	Өөрийн улсын аюулгүй байдлыг төдийгүй хөрш холбоотон улсууд, бүс нутгийн байдлыг хангадаг.	Олон улсын харилцаанд нөлөө багатай.	Гадаад бодлогын хүчин чадал бага ч дэлхий улсуудын 2/3 нь энэ ангилалд багтдаг.
2-р хэсэг	Өөрийн тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэрэгсэлтэй.	Бүс нутагтаа баттай нөлөөлдөг, тогтвортой эдийн засгийн хөгжилтэй улсууд байдаг.	Эдийн засгийн хөгжил буурай, эдийн засаг нь түүхий эд, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжаас ихээхэн хамааралтай.

- А. 1-р хэсгийн А; 2-р хэсгийн В
 С. 1-р хэсгийн Б; 2-р хэсгийн А
 E. 1-р хэсгийн А; 2-р хэсгийн Б

- В. 1-р хэсгийн В; 2-р хэсгийн А
 D. 1-р хэсгийн Б; 2-р хэсгийн В



49. Монгол улс хоёр хөрштэйгөө харилцах зарчимд хамаарахгүй өгөгдөл аль нь вэ? /1 оноо/

- A. Тэнцвэртэй B. Сайн хөршийн C. Стратегийн түншлэл
D. Олон тулгуурт E. Хүмүүнлэгийн

50. Монгол улс Хятад улстай харилцах харилцааны тулгуур баримт бичгүүдийг зөв тохируулна уу. /2 оноо/

a. 1994 он	1	Стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөрөө баталсан.
b. 2011 он	2	Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоосон.
c. 2013 он	3	Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ байгуулсан.
	4	Стратегийн түншлэлийн харилцаа тогтоосон.

- A. a3b4c1 B. a2b4c1 C. a3b1c4 D. a1b4c3 E. a2b3c4

51. Олон улсын байгууллагын үндсэн шинжид ул хамаарах ойлголтыг сонгоно уу. /1 оноо/

1. Засгийн газрууд хамтран байгуулдаг.
2. Хувь хүн, иргэн байгуулах боломжтой.
3. Улс орнуудад илүү нээлттэй, байгууллагын бүтэцтэй.
4. Тодорхой чиглэл, хүрээнд зорилго тавьж хэрэгжүүлдэг.

- A. 1, 2 B. 2, 4 C. 2, 3 D. 1, 3 E. 1, 4

52. Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь зөв харгалзуулна уу. /2 оноо/

a. Либерал онол	1	ОУХ-ны үндсэн тоглогч бүрэн эрхт улс дангаар биш түүнээс гадна ОУБ, томоохон компаниуд, үндэсний болон бусад нийгэмлэг, хувь хүмүүс ОУХ-нд оролцож байдаг.
b. Марксист онол	2	ОУХ-ны үндсэн тоглогчид нь нийгмийн ангиуд байдаг.
c. Неореалист онол	3	ОУХ-ны бүрэн эрхт субъектүүд нь бүрэн эрхт улс, үндэстэн дамнасан корпорацууд, ЗГ-ын бус байгууллагууд, хувь хүмүүс байдаг.
	4	ОУХ-ны тоглогчид нь бүрэн эрхт улс, тэдгээрийн холбоо, эвсэл байна.

- A. a2b1c3 B. a1b4c2 C. a3b2c4 D. a1b2c4 E. a3b1c2

53. Монгол улс ба Турк улсын харилцааны тухай өгүүлэхдээ хамаарахгүй зүйл оруулсан бол аль нь вэ? /1 оноо/

- A. “ТИКА”-гийн шугамаар нийт 30 сая ам долларын техникийн тусламж үзүүлжээ.
B. Монгол улс 1995 оноос Анкарад Элчин сайдын яамаа нээн ажиллуулсан байна.
C. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын цахим архив зэрэг 30 орчим хөтөлбөр, төсөл хэрэгжүүлсэн.
D. Монгол улсад уг улсын хөрөнгө оруулалттай 63 компани бүртгэгдсэнээс 52 нь худалдаа, нийтийн хоолны салбарт байна.
E. Туркийн тал 1996 оноос Улаанбаатарт элчин сайдын яамаа нээн ажиллуулсан байна.

54. Монгол улс гуравдагч хөршийн бодлогын хүрээнд 2018 оны байдлаар Япон, Энэтхэг, БНСУ, АНУ, Канад, Турк, Герман, Австрали зэрэг улсуудтай түншлэлийн харилцаа тогтоосон. Эдгээр улсуудаас стратегийн түншлэл болон өргөн хүрээтэй түншлэлийн харилцаа тогтоосон улсуудыг сонгоно уу. /2 оноо/

- A. Стратегийн түншлэл- Энэтхэг, Япон; Өргөн хүрээтэй түншлэл- Австрали, Канад
B. Стратегийн түншлэл- Япон, Турк; Өргөн хүрээтэй түншлэл- БНСУ, Австрали
C. Стратегийн түншлэл- Энэтхэг, БНСУ; Өргөн хүрээтэй түншлэл- Япон, АНУ, Герман
D. Стратегийн түншлэл- Австрали, Япон; Өргөн хүрээтэй түншлэл- Энэтхэг, Турк
E. Стратегийн түншлэл- Канад, Япон; Өргөн хүрээтэй түншлэл- Австрали, Герман



55. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоно уу. /1 оноо/

..... гэдэг бол хүнлэг байх ёс суртахууныг эрхэмлэн ямар ч үед, аль ч нөхцөлд ядарч зүдэрсэн эмзэг бүлгийн хүмүүсийн эрх ашгийг дээдэлж, тэдний ашиг сонирхлыг хүндэтгэсэн үйл ажиллагаа явуулахыг шийдвэр гаргагчид болон манлайлагчид уриалах, тэднийг ятган үнэмшүүлэх явдал юм.

A. Эдийн засгийн дипломат ажиллагаа

B. Хүмүүнлэгийн дипломат ажиллагаа

C. Соёлын дипломат ажиллагаа

D. Цахим дипломат ажиллагаа

E. Улс төрийн дипломат ажиллагаа

56. Зөөлөн хүчний бодлогыг оновчтой хэрэгжүүлэх зорилгоор МУ-ын ЗГ-ын 2016 оны 2 дугаар тогтоолд МУ-ыг гадаадад сурталчлах хөтөлбөрт тэргүүн ээлжид доорх чиглэлийг тодорхойлсон байдаг. Үүнд хамааралгүй өгөгдлийг сонгоно уу. /2 оноо/

1. Түүх, соёл, урлаг
2. Аялал жуулчлал
3. Монгол хэлний наадам
4. Үндэсний брэнд бараа, бүтээгдэхүүн үйлчилгээ
5. Цагаан сарын баяр, түүний суртал ухуулга
6. Спорт, олон улсын арга хэмжээ

A. 1, 4

B. 3, 6

C. 4, 6

D. 1, 5

E. 3, 5



ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж: Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай нийт 20 оноотой. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.**

2.1. Дараах онол болон сэтгэгчдийн үзэл санааг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /5 оноо/

a. Неомарксист онол	1	Хөдөлмөрийн хуваарь нийгмийн зохион байгуулалтын үндэс болохын зэрэгцээ тэгш бус байдалд хүргэх үндсэн шалтгаан гэж үздэг.
	2	Эрх мэдэл бүхий хэсэг өөрийн ашиг сонирхлоо хэрэгжүүлэх давуу нөхцөлд байх бол бусад нь тэрхүү ашиг сонирхлыг хэрэгжүүлэхээр хүчин зүтгэх нөхцөлд байна.
b. Дэвис ба Мур	3	Үйлдвэрлэлийн хэрэгсэлтэй харилцах харилцааны ялгарлыг үйлдвэрлэлийн харилцаан дахь хянах эрх мэдлийн үзэл санаагаар баяжуулан судалсан.
c. О.Райт	4	Хувь хүний ангийн харьяаллыг нийгэм, эдийн засгийн үзүүлэлтээр хэмжих бус, харин бусад хүмүүсийн зүгээс үнэлэх нэр хүндийн субъектив үнэлгээ, хүндлэлээр хэмжих загварыг боловсруулсан.
d. Бүтэц чиг үүргийн онол	5	Нэг хэсэг байр суурь нь бусдаас илүү чухал бөгөөд илүү өндөр ур чадварыг шаарддаг, хүмүүсийн сонирхлыг татахын зэрэгцээ илүү хүндлэл хүлээж байдаг.
e. Л.Уорнер	6	Өмчөөс гадна эрх мэдлийн ялгарлыг чухалчилдаг. Төр нь ноёрхогч ангийн эрх ашгийг хэрэгжүүлж байдаг гэж үздэг.
	7	Нийгэм, эдийн засгийн индексийн аргачлал нь ажил мэргэжлийн нэр хүндийн зэрэглэлийг тухайн хүний боловсрол, орлогын хэмжээгээр тодорхойлдог.

2.2. Гадаад худалдаа, түүний тухай ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй зөв харгалзуулна уу. /5 оноо/

a. Гадаадын шууд хөрөнгө оруулалт	1	Гадаадын өрсөлдөөнийг дааж чадахааргүй, хөл дээрээ босож байгаа эдийн засгийн шинэхэн салбаруудыг хамгаалахад хэрэгтэй.
	2	Барааг экспортолсноор дотоодод тухайн барааны хомсдол үүсэж улмаар хэрэглэгчид хохирч болно.
b. Протекционист бодлого	3	Улс орнуудын хооронд бараа, үйлчилгээ шилжих хөдөлгөөнийг хэлнэ.
c. Чөлөөт худалдааны бодлого	4	Гадаад худалдаанд төр оролцох ёсгүй, улс орны үйлдвэрлэгчдийн хоорондын өрсөлдөөнийг тэтгэдэг гэж үздэг.
d. Экспортын сөрөг тал	5	Бүтээгдэхүүн экспортлохын оронд гадаадад үйлдвэрийн газар байгуулах эсвэл худалдан авч болно.
e. Олон улсын худалдаа	6	Гадаадын компанийг хянах зорилгоор бус харин үнэт цааснаас ногдол ашиг болон үнэт цаасны ханшны өсөлтөөс орлого олохын тулд хийдэг.
	7	Импорт нэмэгдсэнээр дотоодын зах зээлд түүнтэй ижил төрлийн бараа үйлдвэрлэж байгаа эх орны үйлдвэрлэгчид хохирдог.



2.3 Д.Истоны улс төрийн системийн загварын бүрдэл хэсгүүдийг тохирох өгөгдөлтэй нь зөв харгалзуулна уу. /5 оноо/

a. Шаардлага	1	Бүх нийтийн санал асуулгад оролцох, шийдвэрийг дэмжиж буйгаа илэрхийлэх
	2	Үндэсний олон нийтийн телевиз нийгмийн дэг журмыг тогтоох зорилгоор зөрчлийн тухай хуулийн зохицуулалтыг сурталчлах нэвтрүүлэг хийв.
b. Дэмжлэг	3	Нийгмийн системийн нэгэн дэд систем
c. Шийдвэр	4	Нийгэм, улс төр, эдийн засаг, экологийн зэрэг янз бүрийн системээс гарч буй тулгалтууд
d. Эргэх холбоо	5	Төрийн сангийн дэмжлэгээр гадаадад суралцуулах хөтөлбөрийг батлав.
e. Үйлдэл	6	Улс төрийн системд өөрчлөгдөж буй орчинд дасан зохицох, шинэчлэх өөрийгөө хадгалах бололцоог олгодог.
	7	Төрийн бус, дэд системүүд гаралтын чиг үүргийг гүйцэтгэдэг.

2.4 Хүний эрхийг хамгаалах Олон улсын болон Үндэсний механизмын тулгуур ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /5 оноо/

a. Хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоо	1	Үндэсний хууль тогтоомж, олон улсын болон бүс нутгийн гэрээ, конвенцоор баталгаажуулсан хүний эрхийг төрөөс хэрэгжүүлэх эдийн засаг, нийгэм, хууль зүйн үүрэг биелэгдээгүй байхыг хэлнэ.
	2	Хүн бүрд аливаа эрх мэдлийн зүгээс нөлөөлөх ёсгүй. Өөрийн автономи эрх байдаг.
b. Хүний эрхийг хамгаалах гэрээнд үндэслэгдсэн байгууллага	3	НҮБ-ын Хүний эрхийн байгууллагуудыг дүрмийн үндсэн дээр байгуулагдсан, хүний эрхийг хамгаалах гэрээнд үндэслэн байгуулагдсан байгууллагууд гэж хоёр төрөлд хуваан үздэг.
c. Протокол	4	Хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан баримт бичиг
d. Хүний эрхийн зөрчил	5	Хоёр болон түүнээс дээш улс хуульчлан дагаж мөрдөхөөр баталсан хүний эрхийн гэрээ
e. Хүний эрхийн үзэл баримтлалын шинж	6	НҮБ-ын олон улсын шүүх, Хүний эрхийн хороо, Хүүхдийн эрхийн хороо, Арьс өнгөөр ялгаварлан гадуурхалтыг устгах хороо гэх мэт
	7	Ерөнхий Ассамблей, Хүний эрхийн комисс, Аюулгүйн зөвлөл, Эдийн засаг, нийгмийн зөвлөл гэх мэт

